



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/178

Улаанбаатар хот

Д.Сүхбатыг сургалтад хамруулах тухай


Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдах "Олон улсын хөгжлийн мэдлэгийг хуваалцах чадавхийг дээшлүүлэх сургалт-2019"-д тус албаны Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Дашдондогийн Сүхбатыг 2019 оны 06 дугаар сарын 26-наас 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд хамруулсугай.

2. Д.Сүхбатад дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Д.Сүхбатын ажлыг орон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулж, эзгүй байх хугацаанд нь ажил үүргийн биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга Г.Ууганбаярт даалгасугай.

4. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг мэргэжилтэн Д.Сүхбатад даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

